



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Монголын уламжлалын нэгдсэн намын
дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг болон
намын дарга сонгосныг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг болон намын дарга шинээр сонгосныг бүртгүүлэх өргөдлийг Танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын уламжлалын нэгдсэн намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Нямаас "... Монголын уламжлалын нэгдсэн намын ээлжит бус Их хурал хуралдаж даргаар Л.Өнөрбаярыг сонгосон, намын дүрмийн шинэчилсэн нэмэлт, өөрчлөлтийг баталсан тул бүртгэж өгнө үү" гэх агуулгатай өргөдлийг нийт 287 хуудас баримт, 1 ширхэг флаш дискийн хамт 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын дээд шүүхэд гаргасан.

Дээрх өргөдөл болон түүнд хавсаргасан баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлж, сонсох ажиллагааг хийсэн ба тухайн ажиллагааны явцад 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 2 хуудас тайлбар, 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр 56 хуудас баримт, 1 ширхэг флаш диск, 2026 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 1 хуудас тайлбарыг цахимаар тус тус нэмэлтээр ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд "Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх

арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Монголын уламжлалын нэгдсэн намаас дээрх хугацаанд нийт нэг удаа буюу 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр “намын дарга сонгогдсоныг болон намын дүрмийг бүртгүүлэх” өргөдлийг гаргасан боловч намын дүрмийг баталсан Их хурлын үйл ажиллагаа болон баталсан намын дүрэм хуульд заасан шаардлагыг хангаагүй, зөрчилтэй байсны улмаас Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэхээр дахин нэг удаа Улсын дээд шүүхэд хандах боломжийг олгосны дагуу тус нам нь 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ээлжит бус Их хурлаа хуралдуулан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, намын даргаар Л.Өнөрбаярыг сонгожээ.

Монголын уламжлалын нэгдсэн намаас “намын дарга сонгогдсоныг болон намын дүрмийг бүртгүүлэх” өргөдлийг 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын дээд шүүхэд дахин гаргасан, ингэхдээ Улсын дээд шүүхийн тогтоолд заасан алдаа зөрчлийг засаж, Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ шинэчлэн баталж ирүүлсэн байх тул Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм /Шинэчилсэн найруулга/ болон намын дарга сонгосныг бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг. Ээлжит бус Их хурлыг зарласан тухайд:

Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм (2005 он)-ийн 3.2.4-т “... Намын ээлжит бус Их хурлыг намын Тэргүүлэгчдийн олонхын шийдвэрийг үндэслэн Улс төрийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн 2/3 хувийн бичгээр гаргасан саналаар хуралдуулж болно. Ээлжит болон ээлжит бус Их хурлын хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, сонгох журам, хэлэлцэх асуудлыг намын Тэргүүлэгчдийн хурлаас тогтооно”, 3.2.5-д “Их хурлын товыг 30 хоногийн өмнө зарлана”, 3.4.1-д “Намын Улс төрийн ерөнхий зөвлөл нь намын Их хурлаас сонгогдсон 45 хүртэл ... гишүүдээс бүрдэнэ”, 3.7.2-т “Тэргүүлэгчид нь 11-19 гишүүнтэй байна” гэж тус тус заасан байна.

Монголын уламжлалын нэгдсэн намын Улс төрийн ерөнхий зөвлөлийн 30 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдөр намын ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулж, намын дарга сонгох, намын дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах болон намын Улс төрийн ерөнхий зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох асуудлыг хэлэлцэх саналыг бичгээр гаргасныг үндэслэн намын Тэргүүлэгчдийн 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Ээлжит бус Их хурал хуралдуулах тухай” 1 дүгээр тогтоолд “Монголын уламжлалын нэгдсэн намын ээлжит бус Их хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12 цагт хуралдуулсугай” гэж шийдвэрлэсэн, тус хуралд нийт 11 гишүүнээс 8 гишүүн нь оролцож, 72.6 хувийн ирцтэйгээр хуралдсан, олонхын саналаар шийдвэр гаргасан байх тул намын дүрэм (2005 он)-ийн 3.2.4 дэх заалт болон 3.17.1-д “...

Тэргүүлэгчдийн хурал ... эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэр гаргах бөгөөд дараах заалтуудыг удирдлага болгоно”, 3.17.5-д “Санал хураалтаар дийлэнх олонхын саналаар шийдвэрээ гаргана. Санал хураалтын ирц дараах байдлаар бүрдсэн нөхцөлд шийдвэрийг хүчинтэйд тооцно. 2/Улс төрийн ерөнхий зөвлөлийн хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралд түүний гишүүдийн 2/3-оос доошгүй нь санал өгснөөр” гэж заасан журамд нийцсэн байна.

Тэргүүлэгчдийн 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэрээр товлон зарласан ээлжит бус Их хурлын тов, зарыг 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдөр фэйсбүүк дэх өөрийн намын “Их хурлын төлөөлөгч нар” гэсэн группт болон 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр “Монголын уламжлалын нэгдсэн нам” гэх нэртэй хуудаст тус тус нийтэлж мэдээлсэн нь намын дүрэмд заасан хугацааг баримталсан, намын гишүүд, хуралдаанд оролцох төлөөлөгчдийн эрхийг хангасан байна гэж дүгнэв.

Хоёр. Ээлжит бус Их хурлын Төлөөлөгчдийг сонгосон тухайд:

Тэргүүлэгчдийн 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар баталсан “Ээлжит бус Их хурлын төлөөлөгчдийн тоо болон хэлэлцэх асуудлыг батлах тухай” 2 дугаар тогтоолд “... төлөөлөгчдийн бүрэлдэхүүн 50 гишүүнтэй байна, ... бүрэлдэхүүнийг Тэргүүлэгч гишүүд, Улс төрийн ерөнхий зөвлөлийн гишүүд, ахмад гишүүд, залуу гишүүд, мөн жендэрийн тэгш байдлыг хангаж сонгосугай” гэж, улмаар тус тогтоолын хавсралтаар намын Их хурлын төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг баталжээ.

Монголын уламжлалын нэгдсэн намаас Улсын дээд шүүхэд 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 4 дугаартай албан бичгээр “Тус намын өмнөх мөрдөгдөж байсан дүрэмд Их хурлын төлөөлөгчийг сонгох, томилох нарийвчилсан журам тусгагдаагүй бөгөөд Тэргүүлэгчид намын зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийн хүрээнд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тогтоох боломжтой байсан, ... 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хуралдсан намын Их хуралд оролцсон төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тулгуурласан, намын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор өмнөх бүрэлдэхүүнийг хадгалж, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог гишүүдээ хамруулсан” гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Тус намын дүрэм (2005 он)-ийн 3.2.4-т “... Ээлжит болон ээлжит бус Их Хурлын хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, сонгох журам, хэлэлцэх асуудлыг намын Тэргүүлэгчдийн хурлаас тогтооно” гэж заасан тул төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг Тэргүүлэгчдээс батлан сонгосныг буруутгах үндэслэлгүй гэж үзлээ.

Гурав. Ээлжит бус Их Хурлыг хуралдуулсан тухай:

Монголын уламжлалын нэгдсэн намын ээлжит бус Их хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулж, хуралд төлөөлөгчөөр сонгогдсон 50 төлөөлөгчөөс 38 нь биечлэн оролцсон нь хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл, намын гишүүний үнэмлэх болон баримтаар ирүүлсэн дүрс бичлэг, фото зургаар тогтоогдож байх тул Их хурлын ирц хүрсэн, хуралдааны үйл ажиллагаа намын дүрэмд нийцсэн гэж дүгнэв.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж хуульчилсан. Улсын дээд шүүхээс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр явуулсан сонсох ажиллагааны дараа Монголын уламжлалын нэгдсэн намын Улс төрийн ерөнхий зөвлөл нь гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүйн саналаар 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 86.9 хувийн ирцтэйгээр хуралдаж, “Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай” 6 дугаар тогтоолыг баталсан нь тус хурлын тэмдэглэл, хуралдааны дүрс бичлэг, фото зургийн баримтаар тогтоогдож байна.

Дөрөв. Намын даргыг сонгосон тухайд:

Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй тус намын хувийн хэргээс үзэхэд, Улсын дээд шүүхийн 2012 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Монголын уламжлалын нэгдсэн намын ээлжит 5 дугаар Их хурлаар намын даргаар Батдэлгэрийн Батболд сонгогдсоныг бүртгэсэн байх ба тус намын дүрмийн 3.6.3-т “Намын удирдлагын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд дараагийн удирдлага сонгогдсоноор дуусгавар болно” гэж зааснаар намын дарга Б.Батболдын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон байна.

Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм (2005 он)-ийн 4.2.1-д “Намын гишүүн нь дор дурдсан эрхтэй”, 4.2.1 дэх заалтын 2/-т “намын бүх шатны байгууллагад нэр дэвших, дэвшүүлэх, сонгох, сонгогдох” гэж, 3 дугаар зүйлд “Их хурал нь дараах эрх мэдлийг хэрэгжүүлнэ:”, 3.3.6-д “Намын даргыг сонгох, чөлөөлөх” гэж тус тус заасан, 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан намын ээлжит бус Их хурлаар намын даргыг сонгох асуудлыг хэлэлцсэн, Л.Өнөрбаяр нь намын даргад өөрийн нэрийг дэвшүүлсэн, өөр нэр дэвшигч гараагүй тул нэр дэвших, дэвшүүлэх ажиллагааг хаасныг мэдэгдэж, намын даргыг сонгох нууц санал хураалт явуулсан, санал хураалтад тухайн Их хурлын 36 төлөөлөгч оролцсоноос 97.2 хувийн саналаар Лхагвасүрэнгийн Өнөрбаярыг намын даргаар сонгохыг дэмжсэн болох нь хуралдааны тэмдэглэл, дүрс бичлэгээр тогтоогдож байна.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Нам дараах эрхийг эдэлнэ:” 7.1.3-т “хуульд өөрөөр заагаагүй бол намын бүтэц, зохион байгуулалт, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох”, 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх ...” гэж тус тус заасны дагуу ээлжит бус Их хурлын Төлөөлөгчдийн олонхын саналаар Л.Өнөрбаярыг намын даргаар сонгосон нь хууль болон дүрэмд нийцсэн гэж үзэх үндэслэлтэй.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ” гэж заасан, Монголын уламжлалын нэгдсэн намын 2026 оны 04 дүгээр сарын 25-ны

өдөр хуралдсан ээлжит бус Их хурлын 6 дугаар тогтоолоор намын даргаар Л.Өнөрбаяр сонгогдсоныг баталсан, уг шийдвэрийг 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн нь хуульд нийцсэн байх тул тус намын даргаар Л.Өнөрбаяр сонгогдсоныг бүртгэх нь зүйтэй.

Тав. Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн тухайд:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар тогтоолоор тус намын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хуралдсан Их хурлын 3 дугаар тогтоолоор баталсан намын дүрмийн зарим заалт хуульд нийцээгүй, тухайлбал, намын гишүүнээс “түдгэлзэх, түдгэлзүүлэх үндэслэл”-ийг тодорхой заагаагүй, “намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөн”-ийг тодорхойлоогүй, сахилгын шийтгэлийг намын ямар байгууллагаас ногдуулах, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх журам, мөн сахилгын шийтгэл ногдуулан ямар хугацаанд гишүүний эрхийг түдгэлзүүлэхийг намын дүрэмд тусгалгүй орхигдуулсан, Улс төрийн ерөнхий зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа, нэр дэвшүүлэх, хэлэлцэх, шийдвэр гаргах, санал хураалт явуулах журам, гишүүд хугацаанаасаа өмнө өөрчлөгдөх, чөлөөлөгдөх зохицуулалт зэргийг намын дүрэмд тусгаагүй, намын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх, сонгох эрхийг Тэргүүлэгчид эдлэхээр заасан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д заасанд нийцэхгүй, намын даргыг сонгох, чөлөөлөх талаар намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагын чиг үүрэг давхардсан, намын даргад хэрхэн, яаж нэр дэвших журам тодорхойгүй, намын даргыг огцруулах, чөлөөлөх үндэслэлийг тодорхой нэрлэн заагаагүй нь хуулийн шаардлага хангаагүй, намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийг хуульд заасан зориулалтаар болон салбар, бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг дүрэмд тусгаагүй, бодлогын судалгааны байгууллага намын дэргэд ажиллах зохицуулалтыг намын дүрмээр зохицуулаагүй” зэрэг алдаа зөрчлүүдийг дурдаж, буцаасан.

Монголын уламжлалын нэгдсэн намын 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит бус Их хурлаар намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, улмаар төлөөллийн төв байгууллага болох Улс төрийн ерөнхий зөвлөл нь тус дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцээд, 100 хувийн саналаар баталсан нь 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан Их хурлын 4 дүгээр тогтоол, Тооллогын комиссын 2 дугаар тогтоол, 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр хуралдсан Улс төрийн ерөнхий зөвлөлийн 6 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2 дугаар тогтоол, хурлын тэмдэглэлүүд, фото зураг, дүрс бичлэг болон бусад бичгийн баримтаар тогтоогдож байна.

Монголын уламжлалын нэгдсэн намын ээлжит бус Их хурлын 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/ нь нийт 5 бүлэг, 20 зүйл, 155 хэсэг, 53 заалт, 8 дэд заалт байсан, үүнд Улс төрийн ерөнхий зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 6 дугаар тогтоолоор 25 хэсэг, 3 заалтад өөрчлөлт оруулж, 2 хэсэг, 3 заалтыг нэмэлтээр оруулж, 4 хэсгийг хасаж, хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт гишүүдийн 100 хувийн саналаар, намын удирдах дээд байгууллага болох Их хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах агуулгатайгаас бусад зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан нь 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит бус Их хурлаар

баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн 15.3 хувьд хамаарч байх тул Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т нийцсэн байна.

Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2.1-15.2.10-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байх тул Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцсэн гэж үзэхээр байна.

Дээрх үндэслэлүүдээр Монголын уламжлалын нэгдсэн намын 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит бус Их хурлын 6 дугаар тогтоолоор намын даргаар Лхагвасүрэнгийн Өнөрбаярыг сонгосныг болон тус хурлын 4 дүгээр тогтоолоор баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/, түүнд Улс төрийн ерөнхий зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 6 дугаар тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, бүртгэхээс татгалзах ноцтой зөрчил байхгүй тул намын дүрмийг бүхэлд нь бүртгэхээр тогтов.

Улсын дээд шүүхэд гаргасан өргөдлийг шалгах ажиллагааны явцад тус намаас 2026 оны 05 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн тайлбарт “Дүрмийн 5.1-д “МУНН-ын ээлжит Их Хурлыг Улс төрийн ерөнхий зөвлөлийн олонхын шийдвэрээр эсхүл намын дарга зарлан хуралдуулна” гэж өөрчлөхдөө “ээлжит” гэдэг үгийг хасах ёстой байсан ч редакцийн шинжтэй техникийн алдаа гарч үлдээсэн, дүрмийн 4.5 дахь заалтын зохицуулалтыг боловсруулахдаа Улс төрийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх үед уг зохицуулалт нь намын Их хуралд хамаарахаар ярилцсан боловч дүрмийн эцсийн найруулгад “Их хурал” гэсэн үг техникийн шинжтэй орхигдсон болно” гэж бичгээр тайлбар ирүүлсэн байх тул намын дүрэмд бичигдсэн үг, үсгийн алдааг хянаж, ирүүлсэн тайлбарын дагуу засварлан ёсчилж, дүрмийг Улсын дээд шүүхэд ирүүлэх шаардлагатай болохыг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсгийг баримтлан Монголын уламжлалын нэгдсэн намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.5, 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Монголын уламжлалын нэгдсэн намын даргаар Лхагвасүрэнгийн Өнөрбаярыг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ,
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА